



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А/БЧО

Мандалговь

Эрх шилжүүлэн ажил  
гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 45 дугаар зүйлийн 45.6, 46 дугаар зүйлийн 46.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг: 2018 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэхээр батлагдсан "Хулд сумын сургуулийн спорт заалны барилгын дуусгал" ажлын эрхийг 2015 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр байгуулсан гэрээний үргэлжлэл болгон Хулд сумын Засаг даргад шилжүүлсүгэй.

Хоёр: Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээг гүйцэтгэгчтэй хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулж, ажлыг чанартай гүйцэтгүүлэн, үе шатны ажилд тавих хяналтыг хариуцлагатай зохион байгуулж ажиллахыг Хулд сумын Засаг дарга (Ч.Зоригтбаатар)-д үүрэг болгосугай.

Гурав: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46.3 дахь заалтыг үндэслэн эрх шилжүүлэн гүйцэтгүүлж байгаа хөрөнгө оруулалт, ажлын гүйцэтгэлд байнгын хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  О.БАТ-ЭРДЭНЭ



0200706